

**СҮХБААТАР АЙМГИЙН ТҮМЭНЦОГТ СУМЫН НУТАГТ  
БАЙРЛАХ БАЗАЛТ ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРДЫГ ИЛ АРГААР  
АШИГЛАХ ТӨСЛИЙН 2022 ОНЫ  
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН  
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

/АШИГ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР MV-017482/

/АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР -5095719/

ХЯНАСАН:

БОАЖЯ-ны ны ХБОБНУГ-н мэргэжилтэн...../П. Шинэцэцэг/

БИЕЛЭЛТИЙГ ТАЙЛАГНАСАН:

Говьмастер ХХК-ны Захирал ...../С.Мөнхтуяа /

Говьмастер ХХК-ны Байгал орчны ажилтан :...../О.Шинэдарам/

**2022 он**

## **Агуулга**

- \* Төслийн товч танилцуулга
- \* Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл
- \* Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөний гол зорилт
  1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт
  2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт
  3. Сөрөг нөлөөлийг бууруулах биологийн олон янз байдлын хамгаалах төлөвлөгөөний биелэлт
  4. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт
  5. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт
  6. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт
  7. Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт
  8. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт
  9. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт
  10. Олон нийтэд тайлагнах хуваарь, төлөвлөгөөний биелэлт
  11. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, түүний үр дүнг тайлагнах, хэлэлцүүлэх төлөвлөгөөний биелэлт

## **ХАВСРАЛТ**

- Компани улсын бүртгэлийн гэрчилгээ
- Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл
- 2021 оны Байгаль орчин менежментийн төлөвлөгөөний 50% төлсөн баримт
- Байгаль орчны төлөвлөгөөт аудитын дүгнэлт
- Тээвэрлэлтийн чиглэлийг тогтоосон тухай захирамж
- 2022 оны Ус ашиглах дүгнэлт
- 2022 оны Хэрлэн голын сав газрын захиргаанаас олгосон ус ашиглах зөвшөөрөл, ус ашиглах гэрээ,
- Мөнххаан сумын Баянцогт суманд хийгдсэн дүйцүүлэн хамгаалах ажил гүйцэтгэсэн тайлан
- Аюултай хог хаягдал нийлүүлэх гэрээ
- Хог хаягдал цуглуулах, тээвэрлэх гэрээ орон нутагтай
- Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, түүний үр дүн шинжилгээний хариу

## Төслийн ерөнхий мэдээлэл

**Төслийн нэр:** “Хайлуур жоншийг ил ба далд аргаар ашиглах төсөл”

**Төсөл хэрэгжүүлэгч:** “Говь мастер”ХХК / Улсын бүртгэлийн дугаар: 9011033112,  
**Регистрийндугаар:** 5095719, Ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөл: MV-017482/

**Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:** Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг , 1-р хороо, 2-р 40 мянгат,  
утас: 90001129

**Төсөл хэрэгжих хугацаа:** Уурхайн үйл ажиллагаа нийт 6 жил үргэлжлэх ба эхний жил ил аргаар дараагийн 5 жил далд аргаар олборлолт явуулна.

**Төслийн байршил:** Хайлуур жоншны орд нь Сүхбаатар аймгийн Түмэнцогт сумын нутагт харьяалагдах ба Улаанбаатар хотоос зүүн урагш 460км, Хэнтий аймгийн төв Өндөрхаан хотоос зүүн зүгт 130км, Дорнод аймгийн төв Чойбалсан хотоос баруун зүгт 200км, Сүхбаатар аймгийн Түмэнцогт сумаас баруун урд зүгт 20 км зайд оршдог.

Тус MV-017482 талбай нь байр зүйн зургийн L-49-21 планшет дээр байрлана.





### **Зураг.1 Төсөл хэрэгжих байршлын зураг**

“Говь мастер” ХХК нь 2012 Базальт нэртэй хайлуур жоншны ордын хүдрийн 1а, 1б, 2а, 2б, 3, 4а, 4б биетүүд дээр хайгуулын өрөмдлөгийн ажил гүйцэтгэж ордын нөөцийг 2013 оны 06-р сарын 11-ийн өдрийн ЭБМЗ-ийн хурлаар хэлэлцүүлж батлуулсан байна. Хайлуур жоншны хүдрийн бодитой болон боломжтой /В+С/ нөөцийг 544.46 мян.тн-оор, 38.87%-ийн дундаж агуулгатай хайлуур жоншийг 185.85 мян.тн-оор, хайлуур жоншны хүдрийн бодитой /В/ нөөцийг 155.22 мян.тн-оор 41.85%-ийн дундаж агуулгатай флюоритыг 64.68 мян.тн-оор, хайлуур жоншны хүдрийн боломжтой /С/ нөөцийг 389.24 мян.тн-оор 35.89%-ийн дундаж агуулгатай хайлуур жоншыг 121.17 мян.тн-оор тус тус батлуулсан байна.

“Говь мастер” ХХК нь дээрх нөөцөд үндэслэн АМГТГ-ын ГУУКХ-ээс MV-017482 тооташиглалтын тусгай зөвшөөрлийг авч Уул уурхайн зураг төслийн “Кеестон Ресурс” ХХК-н Базальтын хайлуур жоншны ордыг ил, далд аргаар ашиглах Техник-эдийн засгийн үндэслэлийг 2014 оны 06 дугаар сарын 24-ны өдрийн ЭБМЗ-ийн хурлаар батлуулсан байна.

2018 онд Базальтын хайлуур жоншны ордын хүдрийн биет 2а, 2б дээр ашиглалтын үйлажиллагаа явуулж 26.2 мян.тн хайлуур жоншны хүдэр олборлосон байна. 2011-2012 онд гүйцэтгэсэн геологи хайгуулын ажлын үр дүнгээр ордын хүдрийн биет 2а, 2б дээр бодитой /В/ зэрэглэлээр үнэлгээ өгсөн байна. 2019 онд Базальтын хайлуур жоншны ордын боломжтой /С/ зэргээр үнэлсэн хүдрийн биет 1, хүдрийн биет 3, хүдрийн биет 4 дээр 2018 онд зөвлөх геологич Н.Шийтэр, геологич Ц.Бат-ирээдүй, Д.Гааш, Э.Тулга нар гүйцээх хайгуулын ажлыг хийж, мөн С нөөцийг зэрэглэлийг ахиулан тооцжээ.

Базальтын хайлуур жоншны ордын хүдрийн бодитой болон боломжтой /В+С/ нөөцийг 447.2 мян.тн-оор, 39.78%-ийн дундаж агуулгатай хайлуур жоншыг 177.91 мян.тн-оор, хайлуур жоншны хүдрийн бодитой /В/ нөөцийг 248.21 мян.тн-оор 40.97%-ийн дундаж агуулгатай хайлуур жоншыг 101.68 мян.тн-оор, хайлуур жоншны хүдрийн боломжтой /С/ нөөцийг 199.04 мян.тн-оор 38.3%-ийн дундаж агуулгатай хайлуур жоншыг 76.23 мян.тн-оор тус тус тооцож, ЭБМЗ-ийн 2019 оны 11-р сарын 01-ны өдрийн хурлаар батлуулан Зураг төслийн “Кеестон Ресурс” ХХК-аар ТЭЗҮ-г боловсруулан 2020 онд батлуулжээ.

## **ТӨСЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ГОЛ БОЛОН БОЛЗОШГУЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ**

### ***Шууд нөлөөлөл:***

Хайлуур жоншны ордноос жонш олборлохын тулд хөрс хуулах, геологийн тогтоцыг шууд өөрчлөх, газрын доорх ус, хөрс ургамлын бүтцийн өөрчлөлт, эвдрэл гарах, бэлчээр болон эрдэс түүхий эдийн нөөц, агаарын ба хөрсний бохирдол зэрэг байгалийн төлөв байдал, байгалийн өнгө төрх ландшафтад сөргөөр нөлөөлөх муу талтай байна.

### ***Шууд бус нөлөөлөл:***

Шууд бус нөлөөлөлд хамрагдах бөгөөд тэсэлгээний үед гарах болон нэг дор ажиллаж байгаа хүнд механизмуудын дуу чимээний нөлөөгөөр зэрлэг ан амьтан үргэж дайжих, газрын доорх усны нөөц чанарт нөлөөлөх зэрэг сөрөг нөлөөлөл байгаагаас гадна орон нутгийн нийгэм-эдийн засагт, (хүн амын тоо, бодит орлого нэмэгдэх, үйлдвэр үйлчилгээний салбарын үйл ажиллагааг нэмэгдүүлэх г.м) эерэг нөлөөлөхөөр байна.

### ***Богино хугацааны нөлөөлөл:***

Халаалтын зуух, хүнд механизмуудаас агаарт бохир утаа хаягдах, хөрс бохирдох, өрөмдлөг тэсэлгээний үед болон хөрс чулуу ачих, тээвэрлэх явцад тоос босох, дуу чимээ гарах зэрэг сөрөг нөлөөллүүд нь богино хугацааны нөлөөлөлд багтана. Үүний зэрэгцээ хур бороо багатай агаар хуурайшсан салхитай үед хөрсний овоолго, уурхайн мөргөцөг ба ажлын түвшин, уурхайн дотоод зам зэргээс тоос шороо хийсэх, мөн тэсэлгээний үед их хэмжээний тоос босдог нь ажиллагсадын эрүүл мэнд, орчны хөрс ургамлын бүрхүүлд нөлөөлнө.

### ***Урт хугацааны нөлөөлөл:***

Хайлуур жоншны ордын олборлолтыг одоогийн тооцоогоор ашиглахад олон жилийн нөөцтэй тул байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийн ихэнх нь урт хугацааны нөлөөлөлд хамаарч байгаа бөгөөд энэ нь бараг бүгдээрээ буцалтгүйгээр байгаль орчин, орон нутгийн нийгэм-эдийн засагт нөлөөлөхөөр байна. Иймээс уурхайд олборлолт хийх үед байгалийн унаган төрхийг алдагдуулан, хөрс ургамлын бүтцийг өөрчлөлт элэгдэл эвдрэлд оруулах зэрэг сөрөг нөлөөллийг бууруулах, нөхөн сэргээх ажлыг нарийн дэс дараатай хийх шаардлагатай бөгөөд манай компани нь 2021 онд хүдрийн 2-р бие-т дээр 0,38 га талбайг дотоод овоолгоор нөхөн дүүрэгсэн.

### ***Нөлөөллийн эрчим:***

Хайлуур жоншны ордны ашиглалтын га талбайн хөрсний онцгой эвдрэл, түүний орчны хөрс, ургамлын элэгдэл, бэлчээрийн талбай болон ордын геологийн тогтоцын өөрчлөлт, эрдэс түүхий эдийн нөөцийн багасалт, байгалийн үзэсгэлэнт өнгө төрх өөрчлөгдөн уурхайн хүнхээл бий болно. Энэ төслийн хүчтэй сөрөг нөлөөлөлд геологийн тогтоцын өөрчлөлт, эрдэс түүхий эдийн нөөцийн багасалт, хөрсний эвдрэл, агаарын бохирдолтыг хамааруулж байна.

Үүний зэрэгцээ газрын гадаргын нөөц (ургамал, хөрс) элэгдэлд орох, бохирдох, ландшафтын

**“Говь мастер” ХХК-ны “Базальт” нэртэй хайлуур жонш олборлох ордын  
2022 оны байгаль орчны менежментийн тайлан**

өнгө төрх өөрчлөгдөх зэрэг дунд зэргийн эрчимтэй сөрөг нөлөөлөлд, харин хүн амын орлого нэмэгдэх, орон нутгийн дэд бүтцийг хөгжүүлэхэд эерэг (дунд зэргийн) нөлөөлөлд тус тус хамаарч байна.

**Төслийн болзошгүй сөрөг нөлөөлөл, үргэлжлэх хугацаа, эрчим**

“Базальт” нэртэй хайлуур жонш олборлох ордын байгаль орчинд учруулж болзошгүй нөлөөллийг тодорхойлохдоо нөлөөллийн эерэг болон сөрөг эсэх; шууд, шууд бус нөлөөлөл; буцалттай, буцалтгүй эсэх; нөлөөллийн үргэлжлэх хугацаа, нөлөөллийн эрчим зэргийг тодорхойлов. Нөлөөлөлд өртөгдөх байгаль, нийгэм, эдийн засгийн бүрэлдэхүүн хэсгүүдийг тодорхойлохдоо давхцуулан зураглах арга /overlay analysis/, магадлан жагсаах (checlist) арга зэргийг ашиглав. Нөлөөллийг тодорхойлохдоо эко системийн бүрэлдэхүүн хэсгүүд болон төслийн байршил, шийдэлтэй холбоотой болзошгүй нөлөөлөл гэсэн үндсэн 2 хэсэгт хувааж үзэв.

**Болзошгүй нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим**

Байгаль орчны үзүүлэлт	Шууд	Шууд бус	Өөрөө зохицуулаг	Богино хугацаа	Дунд хугацаа	Урт хугацааны	Буцаж илгээл	Буцалтгүй	Бага зэрэг	Дунд зэрэг	Хүчтэй
<b>1. Байгалийн экосистемийн өөрчлөлт</b>											
Уурхайн ухаш, хөрсний овоолго, зам болон бусад байгууламжаас ургамлын бүлгэмдэл, бүтцэд	-				-					-	
Уурхайн олборлолтын үйл ажиллагаанаас/хөрсхуулалт, олборлолт, овоолго, барилга байгууламж/ хөрсөн бүрхэвч элэгдэх, эвдрэлд орох, дарагдах	-				-					-	
Хөрс хуулалт, хүдэр олборлолтоос Геологийн тогтоцын өөрчлөлт	-					-		-		-	
Хүн, машин техникийн хөдөлгөөн, Тэсэлгээний үед үүсэх дуучимээ, газар шорооны ажилтай холбоотойгоор ойр орчимд нутаглалаг ан амьтлын амьдрах	-				-					-	
Уур амьсгалын/бичил/өөрчлөлт		-		-					-		
<b>2. Байгалийн нөөц, ашиглалт</b>											
Газрын гадаргын нөөц баялаг	-				-			-	-		
Бэлчээр	-				-				-		
Эрдэс түүхий эдийн нөөц	-				-			-	-		
Эрчим хүчний нөөц											
<b>3. Байгаль орчны чанарын өөрчлөлт</b>											

**“Говь мастер” ХХК-ны “Базальт” нэртэй хайлуур жонш олборлох ордын  
2022 оны байгаль орчны менежментийн тайлан**

Шатах тослох материалын хэрэглээ, Хог хаягдал хадгалалт, зайлуулалттай холбоотойгоор	-										
Гадаргын усны бохирдол											
Уулын ажил, тэсэлгээ, илуурхай, Хөрсний овоолго, зам зэрэг гадаргуугаас тоос босох, тээврийн хэрэгсэлийн хөдөлгүүр дэх шаталтаас үүсэх хорт хий зэргээс агаар бохирдох	-			-				-		-	
Шатах тослох материалын хэрэглээ, Хог хаягдал хадгалалт, зайлуулалттай холбоотойгоор	-				-				-		
<b>4. Байгалийн өнгө төрх, түүх соёлын дурсгалт зүйл, археологи, палентологийн олдвор</b>											
Байгалийн үзэсгэлэнт төрх өөрчлөгдөх	-						-				-
Ландшафтын хэлбэр өөрчлөгдөх	-						-				-
Тусгай хамгаалалттай газар нутагт нөлөөлөх											
Түүх соёлын дурсгалт зүйлд нөлөөлөх											
Археологи, палентологийн олдворт											
<b>5. Эдийн засаг, нийгмийн асуудал</b>											
Орон нутгийн орлого нэмэгдэх	+			+						+	
Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох	+			+						+	
Ажлын байр нэмэгдэх	+			+						+	
Уурхайн хэрэгцээг дагаад орон нутгийн үйлчилгээний байгууллагын эрэлт хэрэгцээ	+			+							+
Уурхайн үйл ажиллагаанаас хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх	-			-						-	
<b>Нийт</b>	<b>16</b>	<b>2</b>		<b>7</b>	<b>7</b>	<b>3</b>	<b>3</b>	<b>3</b>	<b>10</b>	<b>7</b>	<b>1</b>

“+” – эерэг нөлөөлөл, “-” – сөрөг нөлөөлөл

Төслийн үйл ажиллагаанаас үзүүлэх шууд нөлөөлөл 16, шууд бус нөлөөлөл 2 байна. Нийт нөлөөллийн 10- бага хүчтэй, 7- дунд эрчимтэй, 1-хүчтэй нөлөөлөлд хамрагдаж байгаа боловч нөлөөллийн эерэг, сөргөөр авч үзвэл бага эрчимтэй нөлөөллийн 3 – эерэг, 7– сөрөг, дунд эрчимтэй нөлөөллийн 1– эерэг, 6–сөрөг буюу төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл нь шууд, богино хугацааны, бага эрчимтэй сөрөг нөлөөлөл байна.

**Төслийн гол сөрөг нөлөөллүүд**

**Газрын гадаргад үзүүлэх гол сөрөг нөлөөлөл**

Газрын гадаргад гүдгэрийн өөрчлөлт өгөх нөлөөллийн эх үүсвэр нь хөрс, хурдас чулуулаг, хүдрийн түр овоолго зэрэг юм.

**Газрын гадарга, хэвлийд үзүүлэх гол сөрөг нөлөөллийн нэгдсэн үнэлгээ**

Байгаль орчны үзүүлэлт	Нөлөөллийн хэлбэр				Нөлөөллийн үргэлжлэх хугацаа			Нөлөөллийн эрчим		
	зайлшгүй		болзошгүй		Богино угацаан	Дундхуг	Уртхуга цааны	Багазэрэг	дундээрэг	Хүчтэй
Шууд	Шуудбус	Шууд	Шуудбус							
Хайлуур жоншны ордыг ашигласны Улмаас Монгол орны хайлуур жоншны хэмжээ 154.7 мян.тн-оор багасна	-					-		-		
Базальтын хайлуур жоншны ордыг Ил аргаар ашиглах явцад 1.2 га талбайн газрын гадарга эвдэрч 11м гүнтэй, 72.9 мян.м <sup>3</sup> хэмжээтэй уурхайн ухааш үүснэ	-				-			-		
Шимт хөрс болон хурдас чулуулгийн улмаас 1.4га талбайд хөрсний овоолго үүсч газрын гадаргын хэв шинж өөрчлөгдөнө	-					-		-		
Уурхайн барилга байгууламж, тосгон зэргийн улмаас 1.4га талбай дарагдаж газрын гадарга элэгдэл, эвдрэлд орно	-					-		-		
Хаягдал чулуулгийн овоолгоос хүчиллэг урсац үүсч газрын гадарга, хэвлийг бохирдуулж болзошгүй			-			-			-	
Засварын газар, шатах тослох материалын агуулах, ШТС-аас шатах тослох материал асгарч газрын гадаргыг бохирдуулах			-			-		-		
Уурхайн тосгоноос гарсан хатуу, шингэн хог хаягдлаар газрын гадарга,хэвлий бохирдох			-			-		-		
Гадаад тээвэрлэлтийн улмаас 10км зам үүсч газрын гадаргыг талхалж	-					-				-
Дүн	6		3		1	8		5	3	1

Нийт 9 нөлөөлөл авч үзсэнээс зайлшгүй болох нөлөөлөл 6,болзошгүй нөлөөлөл 3 байна.Төслийн үйл ажиллагаанаас газрын гадарга,хэвлийд үзүүлэх сөрөг нөлөөлөл дунд зэргийн эрчимтэй, дунд хугацаатай байна.

## **Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөний гол зорилт**

### ***Төсөл хэрэгжүүлэгч: “Говь-Мастер” ХХК***

Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, нарийвчилсан үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэхэд үндсэн зорилго оршино.

Энэхүү төлөвлөгөөгөөр хайлуур жонш олборлох үйл ажиллагаатай холбогдон бий болж болзошгүй сөрөг нөлөөллөөс тухайн нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах үйл ажиллагааны зорилтууд, нөлөөллийг бууруулахаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний хуваарийг тогтоож өгөв.

Мөн тухайн жилийн хяналт, үзлэгээр төрийн захиргааны төв болон орон нутгийн байгууллагууд, холбогдох хяналтын байцаагч нар, төсөл хэрэгжүүлэгч нарт иргэдээс тавьсан шаардлага, хүсэлтийг хэрхэн биелүүлснийг авч үзэж байх ёстой. БОМТ-ний биелэлтийн үр дүнг жилд 1 удаа орон нутгийн засаг захиргааны байгууллага, нутгийн оршин суугчид, сонирхогч талуудад төслийн талаар танилцуулж хэлэлцүүлэг зохион байгуулсан байна.

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний тайланг БОАЖЯСайдын 2014 оны I.06-ны А-05 дугаар тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу хийж гүйцэтгэсэн болно.

Тус БОМТ-ний заалтууд нь гэрээт байгуулагын гэрээгээр хэрэгжүүлэх үүрэг, хуулийн бусад шаардлагатай зөрчилдөх аваас гэрээ болон хуулийн шаардлагыг урьтал баримтлал болгоно.

Тус БОМТ-нд тодорхойгүй элементүүд илэрхий байвал гэрээт байгууллага тухайн элементийг хэрэгжүүлэхээс өмнө “Говь Мастер” ХК-иас тодруулга авна.

“Говь Мастер ” ХХК болон гэрээлэгч байгууллагууд тус байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөгөөр дараах арга хэмжээг хэрэгжүүлэх зорилготой. Үүнд:

1. Байгаль орчын хуулийн нийцлийг хангах (жагсаалт, хавсралт):
2. Нарийвчилсан үнэлгээний заалтуудыг хэрэгжүүлэх, хэрэгжүүлэх боломжтой эсэхийг бодит байдал дээр тодорхойлох, үнэлэлт дүгнэлт өгөх:
3. “Говь Мастер” ХК-ийн байгаль орчны бодлогыг хэрэгжүүлэх:
4. Байгаль орчны төлөвлөгөөг хэрэгжүүлэх хамаарал, хамрах хүрээг тодорхойлох:

### ***1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт***

Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний төлөвлөгөөнд нийт 2.1 сая.төг зарцуулагдахаар төлөвлөгдсөн байна.

***Агаарт үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах арга хэмжээ***



**“Говь мастер” ХХК-ны “Базальт” нэртэй хайлуур жонш олборлох ордын  
2022 оны байгаль орчны менежментийн тайлан**

№	Арга хэмжээ	Хэрэгжүүлэгч	Тайлбар	Ажлын биелэлт
1	Тоос болон тоосонцорын үзүүлэлтийн түвшинг тодорхой давтамжтайгаар, сонгосон цэгүүд дээр хэмжилт хийнэ.	Байгаль орчны мэргэжилтэн	Тоосны шууд хэмжилтийг улирал бүр хэмжиж мэдээллийн санд хадгалж байна	90%
2	Ахуйн хог хаягдлыг богино хугацаанд зайлуулж, хог хаягдлын болон бохирын цэгт тогтсон хугацаанд ариутгал хийнэ.	Олборлогч компани гэрээт байгууллага	Ахуйн хэрэглээний хог хаягдлыг Сүхбаатар аймгийн Түмэнцогт сумын нэгдсэн хогийн цэгт хог хаягдал тээвэрлэх стандартад зориулан зассан машинд өндөрлөгөө, бүтээлгийг тогтмол хэрэглэн ачиж тээвэрлэж байна.	100%
3	Агаарын дээжинд шинжилгээ хийлгэж, агаарын бохирдолын хэмжээг тогтоолгож, холбогдох арга хэмжээ авч ажилллах	Мэргэжлийн итгэмжлэгдсэн лаборатори, байгаль орчны мэргэжилтэн	Цаг уур, орчны шинжилгээний газар байгаль орчин хэмжилзүйн төв лабороторитай хамтран ажиллаж байна	80%
4	Орчны тоосжилтыг бууруулах зорилгоор замын дагуу усалгаа хийх, машины хурдыг хянаж байх	Олборлогч компани	Уурхайн технологийн замын тоосжилтыг бууруулах зорилгоор уурхайд усны машинаар, усалгаа хийж байна	80%

**1.2 Хөрсөн орчинд үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах арга хэмжээ**

№	Арга хэмжээ	Хэрэгжүүлэгч	Тайлбар	Ажлын биелэлт
1	Олон салаа зам гарган хөрс эвдэхээс урьдчилан сэргийлэх	Олборлогч компани Гэрээт компани	Компанийн дотоод журмын дагуу олон салаа зам үүсгэхээс сэргийлэгддэг.	100%
2	Ахуйн хог хаягдал болон нефть бүтээгдэхүүнээр хөрс бохирдохоос хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх, хяналт тавих	Олборлогч компани Гэрээт компани	Ахуйн хог хаягдалаар хөрс бохирдохоос сэргийлж зориулалтын хогийн цэг байгуулсан.	100%

**“Говь мастер” ХХК-ны “Базальт” нэртэй хайлуур жонш олборлох ордын  
2022 оны байгаль орчны менежментийн тайлан**

3	Тогтоосон хугацаанд хөрсний шинжилгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэж, үр дүн дүгнэлт гаргуулах	Мэргэжлийн лаборатори, гэрээт компани	Хөрс судлалын итгэмжлэгдсэн лабораторитай хамтран ажиллаж улирал тутам хөрсний дээж хүргүүлэн шинжигээнд хамруулан ажиллаж байна.	100%
4	Бохирдсон хөрсийг зориулалтын талбайд байршуулж саармагжуулах ажлын туршилтыг эхлүүлэх	Гэрээт компани	Бохирдсон хөрс байрлуулах талбайг засаж бэлдсэн. Одоогоор бохирдсон хөрс гараагүй.	100%

**1.3 Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах арга хэмжээ**

№	Арга хэмжээ	Хэрэгжүүлэгч	Тайлбар	Ажлын биелэлт
1	Унд ахуйн усыг ундны усны стандартад нийцүүлэх судалгааны ажил хийх	Мэргэжлийн лаборатор	“Инженер Геодези” ХХК-ын дэргэдэх Хөрс судлалын итгэмжлэгдсэн лаборатаритай хамтран ажилдаг бөгөөд Унд ахуйн хэрэглээнд ашиглаж байгаа усыг тогтмол шинжлүүлэн ашиглаж байна.	100%
2	Төслийн нөлөөллийн бүсэд байрлах хугдугаад хяналт тавьж усны түвшний хэлбэлзэлийг бүртгэх түүнийг сэргээн засварлах	Олборлогч компани Орон нутгийн малчид,	Улирал бүрд сонгогдсон 5-н малчдын худагт усны түвшин, эрдэсжилт, хатуулгийн хэмжилт хийж байна. Мөн хагас жилд 1 удаа усыг шинжилгээнд хамруулна.	100%

**1.4 Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах арга хэмжээ**

№	Арга хэмжээ	Хэрэгжүүлэгч	Тайлбар	Ажлын биелэлт
1	Зэрлэг амьтдын амьдардаг гол тархац нутаг, уст цэг орчимд хужир шүү, тэжээл тавиж өгсөн	Олборлогч компани Уул уурхайн байгаль орчны мэргэжилтэн	Компанийн дотоод журмын дагуу зэрлэг амьтдын амьдардаг гол тархац нутаг, уст цэг орчимд хужир шүү, тэжээл тавиж өгсөн. Мөнх шувууны үүр байгуулсан.	100%

**“Говь мастер” ХХК-ны “Базальт” нэртэй хайлуур жонш олборлох ордын  
2022 оны байгаль орчны менежментийн тайлан**

<b>2</b>	Гадаад тээврийн зам дагуу болон уурхайн талбайн осол гарч болзошгүй цэгүүд болон хүн, амьтан, мал гардаг хэсгүүдэд тэмдэг тэмдэглэгээ байрлуулах	Олборлогч компани  Уул уурхайн байгаль орчны мэргэжилтэн	Гадаад тээврийн зам дагуу болон уурхайн талбайн осол гарч болзошгүй цэгүүд болон хүн, амьтан, мал гардаг хэсгүүдэд тэмдэг тэмдэглэгээ зохиох хэмжээгээр байрлуулсан	100%
<b>3</b>	Ажилчдыг хууль бусаар ан хийхгүй байхыг анхааруулах, сургалтанд хамруулдаг	Олборлогч компани  ХАБ	Ажилчдыг хууль бусаар ан хийхгүй байхыг анхааруулах, сургалтанд 7 хоногт 3 удаа ХАБЭА ажилтан зохион байгуулдаг	100%

**2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт :**

“Байгаль орчны тухай хууль болон түүнтэй нийцүүлэн гаргасан дүрэм, журам, холбогдох тогтоол захирамж стандартуудыг мөрдлөг болгон ажиллаж байна. Төлөвлөгөөний дагуу нөхөн сэргээлтийн ажил 2024 оноос хойш хийгдэхээр төлөвлөгдсөн. 1986-1987 оны үед хийгдсэн хайгуулын улмаас эвдэрсэн газар болон мөн уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн газарт техникийн нөхөн сэргээлтийн ажлыг хийсэн . Базальт” нэртэй хайлуур жонш олборлох ордын үйл ажиллагаа нь 2018 оны 08 дугаар сарын 26-ний өдрөөс эхлэсэн бөгөөд ашиглалтын 6 дах жилээс ихлэн нөхөн сэргээлтийн ажил хийж гүйцэтгэх байсан боловч бид төлөвлөгөөны дагуу ажилаж чадаагүй бөгөөд 2021 онд Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлангийн нэмэлт тодотгол тайлан батлуулсан. Энэ жил ашиглалтын 3 дах жил боловч бид төлөвлөгөөны дагуу нөхөн сэргээлтын ажил хийгдэх болоогүй хэдийч нөхөн сэргээлтийн ажлыг эхлүүлсэн бөгөөд 2022 онд 1,41 га талбай газрыг нөхөн сэргээгээд байна.

**НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН АЖИЛ ЯВАГДАЖ БАЙГААГ ЗУРГААР ХАРУУЛАВ.**



**Зураг 1**



**Зураг 2**






**Зураг 3**




**Зураг 4**

**НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН АЖЛЫГ ХЭМЖИЛТ ХИЙН AUTOCAD ФАЙЛААР  
ХАУУЛАВ.**





2021 онд хийгдсэн хэмжилтийн DWG зураг



НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН АЖЛЫГ google earth-аас 2021ОНЫ ЗУРГИЙГ ХАРУУЛАВ.







**СҮХБААТАР АЙМГИЙН ТҮМЭНЦОГТ СУМ”БАЗАЛЫТ ”НЭРТЭЙ  
ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРДЫН 2022ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ СӨРӨГ  
НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ, БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ  
БУУРУУЛАХАД ХИЙГДСЭН МОД ТАРИХ АЖИЛ**

### **Агуулга**

1. Оршил.....
2. Мод тарих арга.....
3. Үхрийн нүд тарих арга.....
4. Чацаргана тарих арга .....
5. Хавсралт зургууд.....
6. Дүгнэлт.....

### **Оршил**

Сүхбаатар аймгийн Түмэнцогт суманд орших MV-017482 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй бүхий Базальт нэртэй хайлуур жонш олборлох төслийн 2022 онд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний Дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд эвдэгдсэн газар нөхөн сэргээж ургамалжуулах, тоосжилт дарах сум орон нутагтай хамтарч суманд мод тарих зэрэг ажлыг хийсэн .

**Ажлын зорилго:** Манай орны 18сая га бөгөөд нийт нутаг дэвсгэрийн 8хүрэхгүй хувийг эзэлж байгаа нь ойн нөөцөөр хомс орны тоонд багтдаг. Ой мод багассанаар

- Хөрсний давхарга нимгэрэх
- Ус барих чадвар буурах
- Хөрс үржил шимээ алдах зэрэг олон сөрөг нөлөөлөл үүсдэг

. Үүнээс сэргийлэхийн тоосжилт ,агаарын бохирдлыг багасгадаг зүйл бол байгаль эхийн бидэнд хайрласан ой мод юм . 1га ой мод нь 18сая шоо метр куб агаарыг цэвэршүүлдэг . Ой модны экологийн ач холбогдол ашиг тус нь:

- Олон янзын амьдтын амьдрах таатай орчинг бүрдүүлж өвөлжиж ,ичих орон байр бий болгох,
- усыг жигд барьж хуваарилах , усны эргэлтэт чухал үүрэг гүйцэтгэх
- хур тунадас нэмэх зэргээр усны горимыг зохицуулна
- Агаар бохирдуулагч нүүрсхүчлийн хийг өөртөө шингээж авдаг
- Хүчилтөрөгч өөрөөсөө ялгаруулдаг

Алтыг нь авчихаад авдрыг хаях биш хариуцлагатай уул уурхай буюу байгаль эх хүн төрөлхтний хөгжил хоорондын тэнцвэрт байдлыг хадгалах , газрын хэвлий дэх ашигт

малтмалыг байгаль хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөлөлгүйгээр явуулах эрдэс баялгийн салбар дахь цогц үйл ажиллагааг явуулах юм. Иймээс иргэд, аж ахуй нэгж байгууллагууд байгаль дэлхийгээ хайрлаж МУ-н ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн 1 тэрбум мод тарих үндэсний хөдөлгөөнд идэвхтэй хичээл зүтгэлтэй оролцож байх хэрэгтэй.

## **Мод тарих арга**

### Тарих хугаца

Хаврын улиралд 04.25-наас 06.01-ны хооронд, намрын улиралд 9.25-аас 11.01-ны хооронд мод тарихад тохиромжтой. Энэ хугацаанд мод тарихад хавар бол модны нахиа задраагүй, намар бол навч нь бүрэн хагдарсан байдаг учир амьдрах чадвар сайн байна.

Хаврын суулгац тарихад оройн нахиа хатсан эсэхийг сайн шалгаж авах хэрэгтэй. Оройн нахиа хатсан эсэхийг мэдэхийн тулд суулгацын үзүүрийг хугалж үзнэ. Орой нь хатаагүй суулгацын үзүүр уян зөөлөн байна. Хэрэв хатсан байвал үзүүр нь хатаж хугарсан байх бөгөөд гар хүрмэгц хугарна. Ийм суулгацын амьдрах чадвар муу байдаг. Мөн олон настай хөгшин суулгац амьдрах чадвар муутай байдгийг анхаарах хэрэгтэй. Манай уурхай нь үхрийн нүд чацарганы моднуудыг 2019 оноос хойш тарьж эхэлсэн. Мод бүр өөрийн гэсэн онцлог тарих аргатай. Жишээлбэл мод сөөг Мод, сөөгийн нүхийг ухаж байхдаа үржил шимтэй өнгөн шороог нүхний нэг талд, доод талын үржил шимгүй шороог нүхний нөгөө талд тус тусад нь овоолж, 70-80 см-ийн голчтой, 50-60 см-ийн гүнтэй ухна. Мод, сөөг тарих нүхэндээ 50 хувьд нь хар шороо, 30 хувьд нь элс, 20 хувьд нь хөх бууц сайтар хольж хөрсөө бэлдэнэ. Бэлдсэн хөрсний гол хэсэгт модныхоо үндсийг тараан байрлуулж, шороогоор хучиж, гишгэлэн шороог нягтруулж, агаар орохгүйгээр чигжиж өгнө. Тарьсан модны үндэс нугалраагүй шулуун, үндэсний үзүүр доош чиглэсэн байх ёстой. Тарьц, суулгацыг нүхний ёроолд хэтэрхий гүн суулгаж болохгүй. Модны үндэсний хүзүү нүхний ирмэгийн төвшнөөс 10-15 см доор байрлана. Харин монос суулгацын нүхний диаметр 60 см, гүн нь 50 см хэмжээтэй байвал тохиромжтой. Нүх ухахад гарсан шороог шигшиж, чулуу, хайрга, элдэв хог зэрэг бүхий л хольцоос нь салгаж, ялган зөөж, зайлуулна. Монос суулгах нүхэнд хийх хөрсийг хар шороо 60 хувь, элс 30 хувь, бууц 10 хувь байхаар тооцож бэлтгэнэ. Бэлтгэсэн нүхийг моносны суулгацыг суулгахын өмнө усалж чийгшүүлнэ. Бэлтгэсэн нүхэндээ үржил шимт хөрс шороо хийж, ялимгүй хонхойлоод дээр нь суулгацаа тэгшхэн хийж, эргэн



тойрон шороогоор сайн чигжиж өгнө. Шороо нүхний ирмэгээс 10-15 см дор байхаар бодож суулгах хэрэгтэй. Энэ нь услахад 1 удаа их хэмжээний ус хийх боломж бүрдүүлдэг.

### **Үхрийн нүд тарих**

Манай хамт олон 2019 оноос хойш уурхайн тоосжилт бууруулах үүднээс чацаргана үхрийн нүдийг тарьж эхэлсэн .

- ❖ 2019 онд 70 гаран үхрийн нүд чацарганы мод
- ❖ 2020 онд 200 гаран үхрийн нүд чацарганы мод
- ❖ 2021 онд 100 гаран үхрийн нүд чацарганы мод

Ингээд нийтдээ төсөл хэрэгжиж үйл ажиллагаагаа явуулж эхэлснээс хойш уурхайн кемп тохижилтонд 400-гаад чацаргана үхрийн нүдний моднуудыг тарьж ургуулсан байна.

### **Үхрийн нүд суулгах**

Үхрийн нүд нь янз бүрийн насны олон найлзуур бүхий 1-2.5 м хүртэл өндөр ургадаг, олон наст, жинхэнэ сөөг ургамал юм. Үхрийн нүд нь хөрс, цаг уур, гарал үүслийн онцлог, ургуулах агротехник зэрэг олон хүчин зүйлээс хамааран 10-20 жил амьдарч, 5-7 насандаа хамгийн арвин ургац өгөх ба цаашид жил ирэх тутам жимсний гарц нь буурна. Үхрийн нүдийг намар газар хөлдөхөөс сарын өмнө 9-дүгээр сарын сүүлч, 10-дугаар сарын эхээр суулгах нь хамгийн тохиромжтой хугацаа юм. Мөн хавар суулгаж ч болно. .

### **Нүх ухаж бэлтгэх**

Хагалж бордсон, хог ургамлаас цэвэрлэн тэгшилж зассан талбайд эгнээ хооронд 1.5-2.5 м, ургамал хооронд 1.25-1.5 м зайтай байхаар 50-60 см диаметртэй, 35-40 см гүн нүх ухаж суулгахад бэлтгэнэ.

#### **Үхрийн нүд суулгах**

Суулгацыг цөөн тоогоор хувинд хийж зөөх ба үндсийг нойтон шороотой нь хамт суулгахад үндэс гэмтэхгүй, суулгац хөрсөндөө сайн ургана. Суулгацыг үндэсний хүзүү нүхний амсраас 8-10 см дор байхаар суулгана. Суулгац суулгахад 2 хүн ажиллах ба нэг нь суулгацыг нүхэнд тохируулан барьж, нүхний гуравны хоёрыг дүүртэл овоолж хийсэн бордоонд үндсийг нь жигд

тарааж өгөхөд нөгөө хүн нь хөрсний үлдсэн хар хөрсийг нүхэнд хийн нягтруулж өгнө. Ялангуяа, нүхний дотор захын хөрсийг илүү нягтруулж өгвөл услахад хөрс доош суухгүй, үндэс ил гарахгүй байна. Суулгацаа суулгасны дараа нүхний амсрын эргэн тойронд шороог тэгшилж газрын гадаргаар борооноос ус тогоо руу урсахад саадгүй болгож өгөөд ханатал усалж, хөрсөнд ус гүйцэд шингэсний дараа хөрсний гадаргыг бууцаар 5-10 см зузаан хучиж өгвөл хөрс хагарахгүйгээс гадна хөрсний гадаргаас ус уурших нь багасна.

### **Чацарганы мод тарих**

Чацарганы гол иш тодорхой хугацаанд наслаад өтөлж, хатаж үхэхэд түүний эргэн тойронд үүссэн залуу иш түүний халааг авч, амьдрал нь тасралтгүй үргэлжилдэг онцлогтой. Чацаргана 4-5 насандаа үр жимсээ өгч эхлэх ба 30-40 жил амьдарна. Манай оронд тарималжуулсан хамгийн ургац сайтай сортын нэг мод 25.8 кг, хамгийн бага ургацтай сортын нэг мод 4.8 кг жимс өгдөг байна.

### **Чацарганы эр, эмийг таних арга**

Үрээр ургуулсан чацарганы суулгац эхний үедээ эр, эм нь ялгарч танигдахгүй байснаа 3-5 дахь жилдээ цэцгийн болон мөчрийн нахиатай болох үедээ энэ ялгаа нь тодорч эхэлнэ. Эр чацарганы нахиа намар орой, өвөл, хаврын улиралд задраагүй байхдаа олон давхар хайрстай, хэмжээгээрээ том, хоорондоо ойр байрласан байх ба сайн ажиглавал нэг наст мөчир нь эмийнхээсээ бүдүүн байдаг. Эм чацарганы нэг наст мөчир нь нарийн турьхан, нахиа нь гол төлөв 2 хайрстай, эрийнхээсээ жижиг, хоорондоо хол байрласан байдаг.

### **Нүх ухаж бэлтгэх**

Засаж бэлтгэсэн талбайд 40-50 см өргөн, 35-40 см гүн нүх ухаж, урьдчилан бэлтгэсэн зохих найрлагатай хөрсийг нүхнийхээ гуравны нэгийг дүүртэл овоолж хийнэ.

### **Чацарганы суулгацыг суулгах**

Чацарганы суулгацаа бэлтгэсэн нүхэндээ үндсийг нь жигд тараан суулгаад дээрээс нь үлдсэн хөрсөөр үндэсний хүзүүг 5-7 см далд ортол буулж, эргэн тойронд нь гишгэж, хөрсийг бага зэрэг нягталж өгнө. Тэгш өнцөгт байрлалаар суулгахдаа голд нь эр ургамлыг, эргэн тойронд нь эмийг байрлуулж, суулгана. Цувруулж эгнүүлэн суулгах бол эрийг нь салхины голлох чиглэлийн дээд талд байрлуулж, 8-10 см ургамалд нэг эр ургамал ногдох харьцаагаар суулгахад болно. Чацарганы суулгацыг байнгын талбайд хавар тухайн нутаг, жилийн цаг агаарын онцлогийг харгалзан 4 дүгээр сарын сүүлч, 5 дугаар сарын эхээр нахиа задраагүй байхад суулгах нь

хамгийн тохиромжтой бөгөөд хэрэв намар тарих бол газар хөлдөхөөс 20-40 хоногийн өмнө суулгана. Суулгасан тарьсан хөрсийг бага зэрэг нягтруулж, гишгэн усална.

### Хавсралт зургууд

Чацарганы модыг 40-50см голчтой нүхэнд суулгадаг



Зураг 1. Уурхайн кемп дээрх 45см голчтой чацарганы үндсийг суулгасан байдал

2022оны 5-р сарын 10ны өдөр





Зураг 2. Сүхбаатар аймгийн Түмэнцогт суман дахь 46см-ийн голчтой манай тарьсан  
чацарганы мод

2022оны 5-р сарын 28өдөр

Үхрийн нүдийг 50-60см голчтой нүхэнд суулгана



Зураг.3 53см голч суулгацтай ургаж байгаа үхрийн нүд





**Зураг 4. Хатаж хугарч гэмтсэн ишийг үндэслүүлж байгаа нь**



**Зураг 5. 2022оны 4-р сарын 30ны өдөр чацарганы суулгац бэлтгэж ухсан нүхэнд суулгаж байгаа нь**

Мод тарихдаа хавар намрын улиралд 04.25-наас 06.01-ны хооронд, 9.25-аас 11.01-ны хооронд мод тарихад тохиромжтой байдаг.





Зураг.6 үхрийн нүдний суулгац



Зураг.7 Үхрийн нүдний суулгац үр суулгаж  
байгаа нь

2022 оны 5-р сарын 24 өлөр үхрийн нүдний суулгац ухаж бэлтгэсэн нүхэнд суулгаж байгаа





зураг 8. Зэрлэг ургамал түүж байгаа нь

зураг 9. Зэрлэг ургамал түүхийн  
өмнө

2022оны 8-р сарын 12ны өдөр



**Зураг 10. Зэрлэг ургамал түүсний дараа**

Зэрлэг хогон ургамал нь мод ургах явцад өсөлтийг удаашруулах чийгийн тэнцвэрт байдал алдагдахад хүргэдэг. Тиймээс тухай цаг бүрт нь түүж цэвэрлэж байх хэрэгтэй.





Зураг 11. Чацарганы иш хугарч . хатаж үхэхэд эргэн тойронд үүссэн шинэ иш нь үргэлжлүүлэн ургадаг.





Зураг 12. Хугарч хатсан ишийг үндэслүүлснийхээ дараа суулгацынхаа нүхийг ухаж байгаа нь  
2022 оны 7-р сарын 30ны өдөр



Зураг 13. Сүхбаатар аймгийн Түмэнцогт сумын тохижилтонд тарьсан чацарганы моднууд  
2022 оны 5-р сарын 29ны өдөр





Зураг.14 модоо усалж байгаа  
2022 оны 5-р сарын 17ны өдөр



Зураг15 .Модоо усалж байгаа  
2022оны 6-р сарын 7 өдөр





Зураг 16. 2022оны 6-р сарын 25 ны өдөр



Зураг 17. Модоо усалж байгаа нь 2022оны 7-р сарын 6-ны өдөр





Зураг 18. 2022оны 7-р сарын 20ны өдөр



Зураг19. 2022оны 8-р сарын 5-ны өдөр





**Зураг 18.2022оны 8-р сарын 18ны өдөр**



**Зураг 19. 2022оны 9-р сарын 2-ны өдөр**

### Дүгнэлт

Өдгөө 21-р зуунд байгаль цаг уурын эрс өөрчлөлт, хүний буруутай үйл ажжиллагаа, үйлдвэржилт, бүтээн байгуулалт нь дэлхийн дулааралд ихээхэн хэмжээний нөлөөлөл үзүүлж байна. Ийнхүү агаарын температур нэмэгдэж дэлхийн усны эргэлтийг түргэсгэж ган гачиг, үер усны аюул зэрэг байгалийн гамшигт үзэгдэл үүсэхэд чухал нөлөө үзүүлж байна. Энэ нь дэлхийн улс орнуудын дэд бүтэц, хөдөө аж ахуй биологийн төрөлд зүйлд сөргөөр нөлөөлж болзошгүй бөгөөд хойд өмнөд туйлын мөс цэвэр ус их хэмжээгээр уурших болсон ба чийглэг уур амьсгалтай улс орнуудад далайн түвшин нэмэгдэж хуурай сэрүүн уур амьсгалтай орнуудад цэвэр усны хомсдол үүсэх аюул нүүрлээд байна.

Үүнээс сэргийлэхийн тулд хүн төрөлхтөн байгаль дэлхийгээ хайрлаж илүү минималист энгийн хэрэглээтэй байх нь зүйн хэрэг. Сүүлийн үеийн судалгаагаар 1 жинсэн өмд хийхэд 9,997 буюу бараг 10 мянган литр ус шаарддаг 1 машин үйлдвэрлэхэд 147,972 литр ус ордог байна.

МУ-н Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн тэрбум мод аян улс орон даяар өрнүүлсэн. Манай компани нь 2019 оноос хойш кемп тохижилт болон сум орон нутгийн тоосжилт бууруулах үүднээс чацаргана, үхрийн нүд нийлсэн 400гаран мод тарьсан байна. Мод тарина гэдэг бол ганц сошиалд ертөнцөд гайхуулж, хүрз барьж хажууд нь очиж зургаа авахуулах бус Мод тарих талбайгаа сонгох, нүхээ ухаж бэлтгэх, суулгацаа суулгах, ардчилгаа, усалгаа, хортон шавж зэрлэг хогон ургамлаас хамгаалах зэрэг хамгийн багадаа 3-5 жилийн нөр их хөдөлмөр юм.



**3. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт:**

3.1 Төслийн дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хүрээнд орон нутагт замын гэрэлтүүлэг тавьсан.

**Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний тухайн жилийн төлөвлөгөөний биелэлт , зардал**

<b>Хийх ажил</b>	<b>Гарах үр дүн</b>	<b>Хэрэгжүүлэгч</b>	<b>Төсөв</b>
Сүхбаатар аймгийн Мөнххаан сум Бүрэнцогт багийн нутаг дах Хөх өндөр нэртэй газарт нөхөн сэргээлтийн ажил	Эвдэрч эзэнгүй орхигдсон 1 га газарт техникийн нөхөн сэргээлтийн ажил	Олборлогч компани	6,0
<b>Нийт, сая.төг</b>			<b>6,0</b>


**Нөхөн сэргээлт хийхийн өмнө**



*Нөхөн сэргээлт хийгдэж байгаа үе*



*Нөхөн сэргээлтийн хийгдэсний дараа*





**4. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт: %**

Төсөл хэрэгжих газар айл өрх өртөөгүй учир нүүлгэн шилжүүлэх шаардлагагүй.

**5. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт :**

“Говь мастер” ХХК нь “Базальт” нэртэй хайлуур жоншны ордын ашигт малтмалын хайгуулын XV-013143 тоот тусгай зөвшөөрөлтэй 570.9 га талбайд археологийн авран хамгаалах хайгуул судалгааны ажлыг 2013 оны 07-р сарын 02-ноос 06-ны хооронд ШУА-ийн Археологийн хүрээлэнгээр хийлгэжээ.

Археологийн хүрээлэнгийн хийсэн судалгаагаар ашиглалтын MV-017482 тоот тусгай зөвшөөрөлтэй талбайд археологийн дурсгал бүртгэгдэггүй байна. Харин талбайгаас гадна (урд талд) Баянцагаан-Овоо уулын өвөр, энгэр хэсгээр оршиж байгаа тул түүх соёлын дурсгалт зүйл ашиглалтын явцад хөндөгдөөгүй.

**6. Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт :**

Хайлуур жонш олборлох уурхай нь тэсэлгээний материалаас гадна химийн аюултай хорт бодис ашиглаагүй болно.

**7. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт :**

“Базальт” нэртэй хайлуур жонш олборлох ордын үйл ажиллагаа нь 2022 оны 04 дугаар сарын 01-нээс эхлэсэн бөгөөд тухайн жилд доорх хүснэгтийн дагуу ажилсан болно.

Эх үүсвэрээс гарах хог хаягдлын төрөл	Код	Аюулын зэрэглэл	Жилд гарах нийт хэмжээ Шингэн (м3/жил) Хатуу (тн/жил)	Дахин боловсруулах	Устгах	Хадгалах	Ландфилл	Тээвэрлэгчид хийх



**“Говь мастер” ХХК-ны “Базальт” нэртэй хайлуур жонш олборлох ордын  
2022 оны байгаль орчны менежментийн тайлан**

Ахуйн	Шингэн	Liq w-1	Low	2.7м <sup>3</sup> /жил	-	-	-	
	Хатуу		Low	2.7тн/жил	-	-	-	
Үйлдвэр ийн	Шингэн	LIW-2	-		-	-	-	
	Хатуу	SOLW-2	Low		-	-	-	
Аюулга й	Ашигласан тос		High	-	-	-	-	
	Аккумулято р	BATT X	High	-	-	-	-	
	Тосны шүүр	BABTv	High	-	-	-	-	

**8. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт:**

Төслийн үйл ажиллагааны туршид байгаль орчинд хамгийн бага сөрөг нөлөөтэйгээр үйл ажиллагаа явуулах үүрэг хүлээж, мэргэжлийн боловсон хүчнээс бүрдсэн байгаль орчны асуудал хариуцсан байгаль орчны алба байгуулах ба төслөөс үзүүлж байгаа сөрөг нөлөөллүүдийг бууруулах, арилгах, байгаль орчныг хамгаалах арга хэмжээ авч ажилсан. Төслийн удирдлагын хэмжээнд онцгойлон анхаарч хэрэгжүүлэх арга хэмжээнүүд байсан. Байгаль орчны асуудал нь зөвхөн байгаль орчны ажилтан, мэргэжилтэнүүд анхаарал хандуулах биш захирлаас эхлээд тогооч, цэвэрлэгч, жолооч гээд уурхайн бүхий л ажилтануудын анхаарал хандуулах чухал асуудал учир манай компани нь хамт олноороо сэтгэл нэгдэн ажиллаж чадсан.

2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөны дагуу манай компани нь Байгаль орчны төлөвлөгөөт аудит “Мархал тал” ХХК-р хийж гүйцэтгүүлсэн Мөн 2022 онд уурхайн тосгон орчимд Тэрбум мод тарих үндэсний хөдөлгөөнд нэгдэж улиас, буйлс” чацаргана гэх мэт 500ш мод тарьсан ба 2022оны 10-р сарын 15нд Түмэнцогт сумын Хар ямаат Улсын тусгай хамгаалалт газар мод тарих аянд нэгдэж уурхайн шүүрлийн уснаас өөрийн машинаар 30тн ус зөөвөрлөн хүргэсэн. Тус төлөвлөгөөний биелэлтэнд 5.5 сая.төг зарцуулагдсан .

**9. Олон нийтэд тайлагнах хуваарь, төлөвлөгөөний биелэлт:**

Төсөл хэрэгжүүлэгч нь уурхайн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг хамгийн бага түвшинд байлгах, байгаль орчны бохирдлоос сэргийлэх, тогтвортой уул уурхайг дэмжих үүрэг хүлээсэн бөгөөд ажилчид, орон нутгийн иргэд болон бусад сонирхогч талуудад төслийн байгаль орчны бодлого үйл ажиллагааг нээлттэй болгох, ажил хэрэгч харилцааг дэмжих үүднээс төслийн БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлгансан.

Түмэнцогт сумын багийн өрхүүдээр орж 2022 оны үйл ажиллагааны тухай төлөвлөгөөгөө тайлгансан Иргэдэд “Говь Мастер” ХХК-ын тухай болон байгаль хамгаалах, байгалийн нөөц, ашиглалт, нөхөн сэргээлт, амьтан ургамалд үзүүлэх нөлөөллийн талаар мэдээлэл өгсөн.

**10. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, түүний үр дүнг тайлагнах, хэлэлцүүлэх төлөвлөгөөний биелэлт:**

Тухайн төслийг хэрэгжүүлснээс үүдэн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг тухай бүр илрүүлэх, бууруулах, арилгах зорилгоор байгаль орчны төлөв байдал, шинээр үүсэн бий болсон нөхцөл байдалд ажиглалт, хяналт явуулах үйл ажиллагааны удирдамжийг “орчны

хяналт шинжилгээний хөтөлбөр” гэнэ. Тус хөтөлбөрт нийт 776.600 мян.төг төлөвлөж “ агаар-2, хөрс -5, ус- 1, ургамал-2, амьтан- 2, дуу чимээ-2, орчны хяналт шинжилгээний дээж авсан болно. Доорх багажнуудыг орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт ашиглана.

<i>№</i>	<i>Багажны нэр</i>	<i>Зураг</i>
<i>1</i>	<i>ГрS Garmin байршил тогтоогч</i>	
<i>2</i>	<i>Зургийн аппарат</i>	
<i>3</i>	<i>Dusttrack тоос хэмжилтийн багаж</i>	

Шимт хөрсний чанарыг алдагдуулахгүй салхи үер усны нөлөөгөөр хорогдож багасах мөн тоосжилт үүсэх нөхцөлөөс урьдчилан сэргийлж олон наст ургамлын үрээр ургамалжуулан хадгаллаж байна мөн цаашид нутагын ургамалаар ургамалжуулан ажиллахаар төлөвлөн ажилсан.





Ашиглаж буй судалыг тойруулан мал амьтан орхоос урьдачилан сэргийлэж аюулгүй байдалыг ханган тэмдэг тэмдэглэгээ байршуулан зогоон татсан байдал



Ашиглаж буй судалыг тойруулан мал амьтан орхоос урьдачилан сэргийлэж аюулгүй байдалыг ханган тэмдэг тэмдэглэгээ байршуулан зогоон татсан байдал





Ашиглалтын талбайг тойруулан шувуудын үүр оромж, ангуучлах нутаг, тэдгээрийн идэш тэжээл бологч амьтдын элбэгшил, байршил нутаг зэргийг харгалзан хиймэл 10 ширхэг үүр байгуулсан.



2021 онд Сүхбаатар аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газраас Хог хаягдлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д заасны дагуу мэдээллийн санд бүртгэж 001381 бүртгэлийн дугаар авсан.

Аюултай хог хаягдлыг түр хадгалах хашаанд хадгаллаж БОАЖЯ-ны зөвшөөрөл бүхий “Оргил баялаг мандах” ХХК-д шилжүүлэн ажиллаж байна.

Үйл ажиллагаанаас гарсан хог хаягдлыг тухай бүрт зайлуулж хөрсөн бүрхэвч

Хог хаягдалаа бохирдохоос сэргийлэн хамгаалан ажиллаж байна. Энгийн хог хаягдалаа Түмэнцогт сумын нэгдсэн хогийн цэгт тээвэрлэн зөөвөрлөн хаяж байна.





Авто замын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4 - д " Олон улс , улсын чанартай болон тусгай зориулалтын авто замын чиглэл , чиглэлийн нэр , дугаарыг авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага , нийслэл , орон нутгийн чанартай авто замын чиглэл , чиглэлийн нэр , дугаарыг тухайн шатны Засаг дарга авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцан тогтооно " гэж заасны дагуу Зам , тээврийн хөгжлийн яам нь олон улс , улсын чанартай болон тусгай зориулалтын авто замын чиглэлийг тогтоодог " Базалт " хайлуур жоншны орд газраас Баяжуулах үйлдвэр хүртэлх 12 км шороон зам нь Авто замын тухай хуулийн дагуу олон улс болон улсын чанартай, тусгай зориулалтын авто замын ангилалд хамаарахгүй юм. Иймд манай компани нь Сүхбаатар аймгийн Түмэнцогт сумын засаг даргын 2021 оны 01-р сарын 14-ны өдрийн А/10 дугаар захирамжаар тээвэрлэлтийн чиглэлийг тогтоолгон авто замын маршрут батлуулан ажиллаж байна. Тээврийн чиглэлийн дагуух авто замын засвар, арчлалтыг хийж гүйцэтгэн, тээвэрлэлтийг “Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага MNS 4598;2011” стандартын дагуу зохион байгуулан ажиллаж байна

Тээвэрлэлтийн замыг сажруулж эвдэрсэн хэсгүүдийг нөхөн сэргээлт хийж салаалж гарсан замуудыг хаасан



Тээвэрлэлтийн замыг хайрган хучилт хийж байгаа байдал



Тээвэрлэлтийн замыг сайжруулж Түмэнцогт сумаас ажлын хэсэг гарч сайжруулалтыг шалгасан.



Гадаад тээвэрлэлтийн болон дотоод технологийн замуудыг байнгын усалгаа хийж байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлийг 100% бууруулж ажиллаж байна.

